



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 7,586,226.50 (долоон сая таван зуун наян зургаан мянга хоёр зуун хорин зургаан төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Хархорин-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ж.Бадрахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ...
дугаар тогтоолын хавсралт

"Хархорин -А33А" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Асфальто зүсэгч хөрөө	2007	ш	1	1,465,200.00	1,465,200.00	1,465,200.00	0.00
2	гүний нягтаршуулагч	2003	ш	1	2,426,826.50	2,426,826.50	2,426,826.50	0.00
3	Компактор индүү	2007	ш	2	1,343,100.00	2,686,200.00	2,686,200.00	0.00
4	Өрмийн станок	1998	ш	1	1,008,000.00	1,008,000.00	1,008,000.00	0.00
				5		7,586,226.50	7,586,226.50	0.00
	Нийт хөрөнгийн дүн			5 (тав)		7,586,226.50 (долоон сая таван зуун наян зургаан мянга хоёр зуун хорин зургаан төгрөг тавин мөнгө)	7,586,226.50 (долоон сая таван зуун наян зургаан мянга хоёр зуун хорин зургаан төгрөг тавин мөнгө)	